



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/346

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61-дүгээр тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 25 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн саналыг үндэслэн тус төвийн барилгын цахилгааны гол шугамыг солиход шаардлагатай зардалд 10,000,000 (Арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 10,000,000 (Арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Тухайн зардлаар хэрэгжүүлэх ажлыг хууль журмын дагуу зохион байгуулж, тайлагнан ажиллахыг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төв (Т.Октябрьбаяр)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН